**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 05 өдөр                Дугаар 231                Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Завхан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1 Контрактын гэрээний хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан "Завхан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Манжилжавын Болдыг албан тушаалаас чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

1.2 Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01/1284 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/4758 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан Бандийн Санжсүрэнг "Завхан АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар томилж, контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА                З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА                Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000302

D:\Huraldaanii material\2020 on\2020.05.05 7r huraldaan.docx